



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2021.06.09 № 24

Асуулт тавих тухай

Танай яамнаас Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг Азийн хөгжлийн банк /АХБ/-ны зээлийн санхүүжилттэй 5, Европын сэргээн босголт хөгжлийн банкны зээлийн санхүүжилттэй 5 нийт 10 багц хэсэг бүхий олон улсын тендер зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан хийж гүйцэтгүүлж байгаа. Энэхүү зам барилгын нийт ажлаас АХБ-ны зээлээр санхүүжигдэж байгаа Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаар ажил явагдаж байгаа боловч Багц 1-2, Багц 1-4 дугаар ажил хийгдэхгүй байсаар өнөөдрийг хүрч байна.

Миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тус замын барилгын ажлын Багц 1-2, Багц 1-4 ажил саатсантай холбогдуулан дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн замын Багц 1-2 болон Багц 1-4 ажлын гүйцэтгэгч байгууллагаар шалгарсан "Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп"-ийг сонгон шалгаруулсан, гэрээ байгуулсан үйл явц болон 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан гэрээнд хийсэн эрх зүйн дүгнэлт, мөн хууль хяналтын байгууллагаар шалгуулсан бол энэ талаарх мэдээлэл, шалгуулаагүй бол яагаад энэ талаар ажиллаагүй байгаа талаар;

2. Тус замын АХБ-ны зээлийн санхүүжилттэй урсгалын Багц 1-2, Багц 1-4 дугаар ажлыг гацаанаас гаргаж эхлүүлэх, барьж дуусгахаар ямар ажил төлөвлөн хэрэгжүүлж байгаа талаар;

3. БНХАУ-ын "Чайна стэйт Шинжиан Констракшн инженеринг групп"-тэй байгуулсан гэрээг Монгол Улсад хохирол багатайгаар цуцлах, АХБ болон бусад оролцогч талуудтай зам барилгын ажлыг эхлүүлэх талаар хамтран хийж байгаа ажлууд түүнчлэн шинээр гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлын явцын талаар;


4. Туслах, түр зам нь эвдрэл ихтэйгээс осол аваар ихээр гарч иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирч байгаа тухай гомдол, санал тасралтгүй ирсээр байгааг анхаарч засварын ажлыг эвдрэл гарсан тухай бүрд нь хэрхэн хийж гүйцэтгэж байгаа талаар болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар;

5. Тус замтай холбоотой иргэдийн гомдол, саналыг гүйцэтгэгч компани тус бүрээс болон өөрийн яамны зүгээс хэрхэн шийдвэрлэж байгаа талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт зааснаар 14 хоногийн дотор дэлгэрэнгүй байдлаар бичгээр өгөх, мөн холбогдох мэдээлэл, баримтуудыг хуулбар үнэн тэмдэг дарж хавсаргаж ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Г.ДАМДИННЯМ